



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 125

Улаанбаатар хот

Тусламж, үйлчилгээг
зохицуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 12 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Лавлагаа төвүүдийн хяналтанд байдаг нийслэлийн иргэдийг дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд үе шаттайгаар шилжүүлэх ажлын хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлэгт 2015 онд чихрийн болон чихрийн бус шижин өвчнөөр шинээр оношлогдож хяналтанд байгаа иргэдийг хяналтанд орсон хугацаанаас нь эхлэн, 2015 оноос өмнө чихрийн болон чихрийн бус шижин өвчнөөр хянагдаж байгаа бүх иргэдийг 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн хяналтанд шилжүүлсүгэй.

2. Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвд чихрийн болон чихрийн бус шижин өвчний хяналтыг шилжүүлсэнтэй холбогдуулан иргэдийг мэдээллээр хангах, тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга /Ц.Төмөр-Очир/-д, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-т тус тус даалгасугай.

3. Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хяналтанд шилжүүлсэн оюуны хүнд хэлбэрийн хомсдолтой үйлчлүүлэгчдэд үнэгүй олгогдох эмийг 2015 оны санхүүжилтыг дуустал бүрэн ханган олгохыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Насанцэнгэл/-д даалгасугай.

4. Оюуны хүнд хэлбэрийн хомсдолтой, чихрийн болон чихрийн бус шижинтэй үйлчлүүлэгчдийг дүүргийн эрүүл мэндийн төвийн хяналтанд шилжүүлсэнтэй холбогдуулан үнэгүй олгогдох эм, тарианы төсвийг 2016 оны төсөвт шилжүүлэн тооцон суулгахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Г.Баярсайхан/-т, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/-т тус тус үүрэг болгосугай.

5. Хүүхдийн хавдрын тусламж, үйлчилгээний туяа эмчилгээнээс бусад үйлчилгээг 2016 оноос Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд шилжүүлэх болсонтой холбогдуулан бэлтгэл ажлыг хангах хамтарсан ажлын хэсгийг байгуулж, зохион байгуулалтын арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж, санхүүжилтийг төсөвт суулгах тооцоо үндэслэлийг гаргаж, төсөвт суулгахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Г.Баярсайхан/-т, ЭХЭМҮТ-н ерөнхий захирал /Ш.Энхтөр/-д, Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Төмөрбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

080423

6. Энэ тушаалын хэрэгжилтэнд мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА